

"Их тэнгэр" цогцолбор

Аудитын код: САГ-2017/1/СТА-ТШЗСН

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.ikhtenger.mn

Тэргүүлэх аудитор: С.Энхзаяа

Утас: 261663, 99117973

Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Болд

Утас: 261628, 99017100

Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Цэрэнхүү

Утас: 261628, 99008695

Цахим хаяг: tserenkhuu_audit@yahoo.com, tserenkhuuts@audit.gov.mn

Аудитор: Р.Цолмон

Утас: 261628, 91918652

Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn

Аудитор: П.Цэнгүүн

Утас: 261885, 99882055

Цахим хаяг: tsenguunp@audit.gov.mn

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.12 Шилэн дансны мэдээлэл	10
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал	12
3.1 Дуусаагүй барилга, байгууламж	13
3.2 Авлага.....	14
3.3 Зөвлөмжийн биелэлт.....	15
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	16
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	16
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	18
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	23

1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/253
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Их тэнгэр” цогцолборын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

“Их тэнгэр” цогцолбор нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0216SAG13.Docx

070119

Зөрчилгүй санал дүгнэлт

“Их тэнгэр” цогцолборын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА



2 Аудитын тайлан

2.1 Оршил

“Их тэнгэр” цогцолборын дарга, хошууч Цэдэн овогтой Оргодол танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Их тэнгэр” цогцолбор-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Их тэнгэр” цогцолборын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 28-наас 2017 оны 2 дугаар сарын 12-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 15-нд эцэслэн

баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Ахлах аудитор Ц.Цэрэнхүү, Аудитор Р.Цолмон, П.Цэнгүүн нар хариуцан хэрэгжүүлэв.

“Их тэнгэр” цогцолбор нь 2016 он оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 46 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлд “Төрийн тусгай хамгаалалт нь аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хуулиар төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон төрийн байгууллага, тэдгээрийн зарим үйл ажиллагаа, албан тушаалтан, иргэний амь бие, ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийг хамгаалахад чиглэсэн мэргэжлийн болон бусад байгууллага, албан тушаалтны харилцан уялдаатай цогцолбор үйл ажиллагаа мөн” гэж заасан байна.

“Их тэнгэр” цогцолбор нь тайлант онд мэдлэг, ур чадварыг эрхэмлэсэн, хариуцлага, хяналтыг үндсэн зарчим болгож зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний стандартын шаардлагыг хангасан шилдэг байгууллага болохыг эрмэлзэнэ гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

“Их тэнгэр” цогцолборын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

“Их тэнгэр” цогцолборын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Их тэнгэр” цогцолборын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

“Их тэнгэр” цогцолборын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 2 буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

“Их тэнгэр” цогцолборын санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Interactive BI” LLC, Emerald програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

“Их тэнгэр” цогцолборын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 4 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 12 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих–шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь зардлын хэсэгт аудитын эрсдэл их байдаг тул нийт зардлыг сонгож авав.

“Их тэнгэр” цогцолборын 2016 он оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,075,0 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 61.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь тухайн онд нэмэлт санхүүжилтийн дансаар 142.1 сая төгрөг АСЕМ-тай холбогдуулан зарцуулагдсан учир 2 хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын түвшин болон хувь хэмжээг хэвээр авч үзэв.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 3 чиглэлээр 6 эрсдэлтэй асуудалд 6 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 83 хувь буюу 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төг)				
№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	3	2,245.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	3	2,245.7	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав. Үүнд:

1."Их тэнгэр" цогцолборын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй байгаа инженерийн шугам сүлжээ шинэчлэл, бохир усыг төвийн шугаманд холбох ажил 2,209.7 сая төгрөгөөр бүртгэлтэй байна. Дээрх ажлыг 2013 оны 9 дүгээр сарын 01/55/2013 дугаар актаар Улсын комисс хүлээн авсан боловч үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж аваагүй, элэгдэл тооцоогүй байна.

Энэ нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”, “Толилуулга ба тодруулга” аудитын батламж мэдэлдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй 2,209.7 сая төгрөгийн ажлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөв.

2. Санхүүгийн тайланд тусгасан авлагыг анхан шатны баримт болон тооцоо нийлсэн акттай тулган баталгаажуулахад төлбөртэй үйлчилгээний 9.3 сая, хувь хүнээс авах 11.3 сая төгрөгийн авлагыг үүсгэж, баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гаргахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж өгөв.

3. Өмнөх аудитын зөвлөмжөөр 2002 оноос өмнө үүссэн 3 байгууллага, 17 хувь хүнд холбогдох 15.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж барагдуулах талаар зөвлөмж өгсөн боловч биелүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: 3 байгууллага, 17 хувь хүнд холбогдох 15.1 сая төгрөгийн хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөв.

2.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Их тэнгэр” цогцолбор нь Тагнуулын Ерөнхий газрын даргын 2017 оны 1 дүгээр сарын А/02 тоот тушаалаар “Их тэнгэр” цогцолборын санхүүгийн тайланг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгож, Төрийн тусгай хамгаалалтын газрын санхүүгийн тайланд нэтгэхээр шийдвэрлэсэн байна.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

“Их тэнгэр” цогцолбор өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 2,301.9 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,301,934,700.00	2,280,709,302.50	99.1	21,225,397.50
1.1	Урсгал зардал	2,301,934,700.00	2,280,709,302.50	99.1	21,225,397.50
1.2	Хөрөнгийн зардал	0	0		0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0		0.0
2	Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр				
2.1	Улсын төсвөөс санхүүжих				
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос				

Төсөвт зардлын гүйцэтгэл 99.1 хувь байгаа нь 2016 оны батлагдсан төсөв 2,301.9 сая төгрөг, гүйцэтгэл 2,280.7 сая төгрөг нийт төсвийн хэмнэлт 21.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 40.8 сая төгрөгөөр тасарсан, туслах үйл ажиллагааны орлогыг 60.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Учир нь эдийн засгийн хямралтай холбоотойгоор төрийн байгууллагын хурал, семинар багассан, акталсан дулааны шугамыг 50.4 сая төгрөгөөр худалдсантай холбоотой байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

“Их тэнгэр” цогцолбор нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 85 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг “Их тэнгэр” цогцолборын 2016 оны завсрын аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

Урьд оны аудитын зөвлөмжөөр 2002 оноос өмнө үүссэн 3 байгууллага, 17 хувь хүнд холбогдох 15.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж барагдуулах талаар зөвлөмж өгсөн боловч биелүүлээгүй байна.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Их тэнгэр” цогцолборын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Их тэнгэр” цогцолборын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Их тэнгэр” цогцолборын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолоор нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 ДУУСААГҮЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Илрүүлэлт

“Их тэнгэр” цогцолборын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй байгаа инженерийн шугам сүлжээ шинэчлэл, бохир усыг төвийн шугаманд холбох ажил 2,209.7 сая төгрөгөөр бүртгэлтэй байна. Дээрх ажлыг 2013 оны 9 дүгээр сарын 01/55/2013 дугаар актаар Улсын комисс хүлээн авсан боловч үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж аваагүй, элэгдэл тооцоогүй байна. Энэ нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”, “Толилуулга ба тодруулга” аудитын батламж мэдэлдлийг хангахгүй байна.

Зөвлөмж

Дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй 2,209.7 сая төгрөгийн ажлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлэх.

Хариуцах ажилтан

Ахлах нягтлан бодогч Э.Ариунчимэг

Эрсдэл

Дуусаагүй барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй хөрөнгийг үндсэн хөрөнгөнд бүртгээхгүйгээс элэгдэл тооцогдохгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрч байна.

3.2 Авлага

Илрүүлэлт

Санхүүгийн тайланд тусгасан авлагыг анхан шатны баримт болон тооцоо нийлсэн акттай тулган баталгаажуулахад төлбөртэй үйлчилгээний 9.3 сая, хувь хүнээс авах 11.3 сая төгрөгийн авлагыг үүсгэж, баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гаргахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Зөвлөмж

Авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Хариуцах ажилтан

Ахлах нягтлан бодогч Э.Ариунчимэг

Эрсдэл

Авлага нэмэгдэх, авлагыг цаг тухай бүр барагдуулаагүйгээс найдваргүй авлага үүсэх.

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрч байна.

3.3 Зөвлөмжийн биелэлт

Илрүүлэлт

Өмнөх аудитын зөвлөмжөөр 2002 оноос өмнө үүссэн 3 байгууллага, 17 хувь хүнд холбогдох 15.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж барагдуулах талаар зөвлөмж өгсөн боловч биелүүлээгүй байна.

Зөвлөмж

3 байгууллага, 17 хувь хүнд холбогдох 15.1 сая төгрөгийн хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх.

Хариуцах ажилтан

Ахлах нягтлан бодогч Э.Ариунчимэг

Эрсдэл

Урьд оны зөвлөмж биелүүлээгүйгээс алдаа зөрчил давтагдах.

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрч байна.

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	727,509,748.51	837,890,193.81
33	АВЛАГА	97,843,247.22	96,826,383.09
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	62,809,342.95	43,739,184.48
33401	Дансны авлага /ТӨҮГ/	15,097,734.23	15,097,734.23
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		11,008,342.34
335	Бусад авлага	19,936,170.04	26,981,122.04
3351	Байгууллагаас авах авлага	5,137,230.04	6,964,682.04
3352	Хувь хүмүүсээс авах авлага	14,798,940.00	20,016,440.00
35	БАРАА МАТЕРИАЛ	629,666,501.29	741,063,810.72
351	Түүхий эд материал	167,815.53	126,231.31
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал	167,815.53	126,231.31
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн	33,883,047.91	35,416,304.36
354	Хангамжийн материал	595,615,637.85	705,521,275.05
35410	Бичиг хэргийн материал	6,001,843.65	5,049,415.97
35420	Аж ахуйн материал	264,436,073.26	315,362,600.81
35430	Сэлбэг хэрэгсэл	641,620.79	442,721.27
35440	Түлш, шатах тослох материал	1,086,744.50	662,079.90
35450	Барилгын засварын материал	8,359,403.38	5,443,738.23
35460	Хүнсний материал	27,210,984.27	31,249,763.67
35470	Бусад хангамжийн материал	287,878,968.00	347,310,955.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,862,167,484.37	7,441,545,393.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,862,167,484.37	7,441,545,393.69
391	Газар		
392	Биет хөрөнгө	7,857,538,478.39	7,437,687,886.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	19,723,224,263.86	20,011,355,263.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,651,242,151.84)	(15,196,249,236.63)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	232,768,562.00	232,768,562.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(174,859,603.43)	(204,519,793.25)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	586,406,710.37	585,581,710.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	(441,597,539.16)	(496,096,794.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,151,291,523.85	1,152,116,523.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(778,155,123.26)	(856,970,185.26)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	2,209,701,836.00	2,209,701,836.00
393	Биет бус хөрөнгө	4,629,005.98	3,857,507.26

39301	Програм хангамж	9,059,600.00	9,059,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,059,600.00)	(9,059,600.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,698,138.61	7,698,138.61
39304	Хуримтлагдсан элэгдэл	(3,069,132.63)	(3,840,631.35)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8,589,677,232.88</u>	<u>8,279,435,587.50</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>31,311,535.00</u>	<u>144,023,781.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>31,311,535.00</u>	<u>144,023,781.00</u>
413	Өглөг	2,989,794.20	126,935,781.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	71,279.00	2,773,781.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		84,700.00
4136	Бусад өглөг	2,918,515.20	124,077,300.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,918,515.20	124,077,300.00
414	Урьдчилж орсон орлого	28,321,740.80	17,088,000.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	28,321,740.80	17,088,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,558,365,697.88</u>	<u>8,135,411,806.50</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>8,558,365,697.88</u>	<u>8,135,411,806.50</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	10,361,771,653.49	10,361,771,653.49
51101	Өмч: - төрийн	10,361,771,653.49	10,361,771,653.49
512	Хуримтлагдсан үр дүн	<u>(3,000,275,220.12)</u>	<u>(3,423,229,111.50)</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	(653,954,136.88)	(3,000,275,220.12)
51220	Тайлант үеийн үр дүн	(2,346,321,083.24)	(422,953,891.38)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,196,869,264.51	1,196,869,264.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>8,589,677,232.88</u>	<u>8,279,435,587.50</u>

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,286,133,943.75	2,652,067,349.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,439,364,882.40	878,150,749.24
120	Нийтлэг татварын бус орлого	1,439,364,882.40	878,150,749.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,282,523,029.66	688,328,945.91
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	859,631,674.65	688,328,945.91
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	422,891,355.01	0.00
120005	Түрээсийн орлого	142,969,746.40	119,731,980.80
120009	Бусад орлого	13,872,106.34	70,089,822.53
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,846,769,061.35	1,773,916,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,846,769,061.35	1,466,826,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,557,443,816.35	1,466,826,600.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	289,325,245.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	307,090,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	307,090,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,632,446,398.99	3,075,021,240.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,109,021,671.99	3,075,021,240.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,077,082,237.99	3,038,017,325.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,458,912,699.58	1,353,800,756.59
210101	Үндсэн цалин	1,458,912,699.58	1,353,800,756.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,442,117.20	139,438,932.55
210201	Тэтгэврийн даатгал	88,576,116.07	113,965,151.96
210202	Тэтгэмжийн даатгал	10,143,831.00	4,846,705.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,495,376.79	5,966,223.20
210204	Ажилгүйдлийн даатгал	2,429,997.00	1,154,121.50
210205	Эрүүл мэндийн даатгал	27,796,796.34	13,506,730.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	350,502,431.00	353,186,445.00
210301	Гэрэл, цахилгаан	154,874,160.00	172,717,903.00
210302	Түлш, халаалт	163,744,933.00	142,070,562.02
210303	Цэвэр, бохир ус	31,883,338.00	38,397,979.98
2104	Хангамж, бараа материалын зардал	146,560,822.16	128,994,796.37
210401	Бичиг хэрэг	10,022,166.97	3,405,330.20
210402	Тээвэр, шатахуун	47,936,838.43	49,304,265.57
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,996,710.83	11,157,974.80

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,595,000.00	16,574,680.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	39,056,301.83	40,127,724.17
210408	Бараа материал акталсны зардал	25,953,804.10	8,424,821.63
2105	Нормативт зардал	332,706,898.52	293,284,727.42
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	98,999.47	68,926.76
210502	Хоол, хүнс	321,510,515.21	275,999,922.02
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,097,383.84	17,215,878.64
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,587,063.31	53,387,305.62
210604	Урсгал засвар	52,587,063.31	53,387,305.62
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,503,479.06	7,171,270.88
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	4,200,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,257,475.00	2,845,388.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	246,004.06	125,882.88
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	584,866,727.16	708,753,090.68
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	584,866,727.16	708,753,090.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,939,434.00	37,003,915.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,939,434.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,939,434.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	37,003,915.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	37,003,915.31
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,523,424,727.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,523,424,727.00	0.00
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	2,523,424,727.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(2,346,312,455.24)	(422,953,891.18)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,628.00	0.00
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	8,628.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(8,628.00)	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(2,346,321,083.24)	(422,953,891.18)

СТЗ-А

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,485,234,203.39	2,422,799,302.50
ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	912,807,887.04	850,886,617.81
Нийтлэг татварын бус орлого	912,807,887.04	850,886,617.81
Төсөв байгууллагын өөрийн орлого	750,278,635.84	740,763,817.81
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	750,278,635.84	740,763,817.81
Түрээсийн орлого	162,529,251.20	110,122,800.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,572,426,316.35	1,571,912,684.69
Улсын төвлөрсөн төсвөөс	1,557,443,816.35	1,429,822,684.69
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,557,443,816.35	1,429,822,684.69
Нэмэлт санхүүжилтийн орлого	14,982,500.00	142,090,000.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,982,500.00	0.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	142,090,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,484,354,203.39	2,422,799,302.50
УРСГАЛ ЗАРДАЛ	2,484,354,203.39	2,422,799,302.50
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,452,414,769.39	2,422,799,302.50
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,462,086,244.35	1,377,266,800.00
Үндсэн цалин	1,392,228,644.35	1,312,342,300.00
Унаа хоолны хөнгөлөлт	69,857,600.00	64,924,500.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,606,975.80	123,939,200.00
Тэтгэврийн даатгал	88,740,974.00	102,801,252.00
Тэтгэмжийн даатгал	10,143,831.00	4,029,570.00
ҮОМШӨ-ний даатгал	12,495,377.46	4,945,322.00
Ажилгүйдлийн даатгал	2,429,997.00	957,849.00
Эрүүл мэндийн даатгал	27,796,796.34	11,205,207.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	350,575,231.00	337,000,000.00
Гэрэл, цахилгаан	154,874,160.00	172,717,903.00
Түлш, халаалт	163,817,733.00	125,884,117.02
Цэвэр, бохир ус	31,883,338.00	38,397,979.98
Хангамж, бараа материалын зардал	107,601,122.62	181,016,340.50
Бичиг хэрэг	2,260,090.00	2,628,800.00
Тээвэр, шатахуун	47,587,400.00	51,575,050.00

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,706,919.41	11,542,470.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,200,000.00	14,374,680.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37,846,713.21	100,895,340.50
Нормативт зардал	303,225,892.40	317,833,016.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	266,815.00	30,500.00
Хоол, хүнс	289,089,017.40	277,853,541.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,870,060.00	39,948,975.00
Эд хогшил, урсгал засварын зардал	72,336,803.22	77,343,946.00
Багаж, техник, хэрэгсэл	40,755,543.22	15,063,858.00
Тавилга	0.00	23,283,000.00
Урсгал засвар	31,581,260.00	38,997,088.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	4,200,000.00
Даатгалын үйлчилгээ	0.00	4,200,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	14,982,500.00	4,200,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	14,982,500.00	4,200,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,939,434.00	0.00
Бусад урсгал шилжүүлэг	31,939,434.00	0.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,939,434.00	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>880,000.00</u>	<u>0.00</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	880,000.00	0.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	880,000.00	0.00
Дотоод эх үүсвэрээр	880,000.00	0.00
Тоног төхөөрөмж	880,000.00	0.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(880,000.00)</u>	<u>0.00</u>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

СТ-4А

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,361,771,653.49	1,196,869,264.51	-653,954,136.88	10,904,686,781.12
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,361,771,653.49	1,196,869,264.51	-653,954,136.88	10,904,686,781.12
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-2,346,321,083.24	-2,346,321,083.24
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,361,771,653.49	1,196,869,264.51	-3,000,275,220.12	8,558,365,697.88
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,361,771,653.49	1,196,869,264.51	-3,000,275,220.12	8,558,365,697.88
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-422,953,891.38	-422,953,891.38
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,361,771,653.49	1,196,869,264.51	-3,423,229,111.50	8,135,411,806.50

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,301,934,700.00	2,280,709,302.50	21,225,397.50	99.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,301,934,700.00	2,280,709,302.50	21,225,397.50	99.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,298,414,600.00	2,280,709,302.50	17,705,297.50	99.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,377,266,800.00	1,377,266,800.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	863,854,200.00	1,312,342,300.00	(448,488,100.00)	151.9
210102	Нэмэгдэл	416,818,300.00	0.00	416,818,300.00	0.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	96,594,300.00	64,924,500.00	31,669,800.00	67.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,939,200.00	123,939,200.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	102,801,252.00	102,801,252.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,029,570.00	4,029,570.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,945,322.00	4,945,322.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	957,849.00	957,849.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,205,207.00	11,205,207.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	337,000,000.00	337,000,000.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	169,000,000.00	172,717,903.00	(3,717,903.00)	102.2
210302	Түлш, халаалт	136,000,000.00	125,884,117.02	10,115,882.98	92.6
210303	Цэвэр, бохир ус	32,000,000.00	38,397,979.98	(6,397,979.98)	120.0
2104	Хангамж, бараа материалын зардал	119,727,200.00	119,209,340.50	517,859.50	99.6
210401	Бичиг хэрэг	2,136,300.00	2,628,800.00	(492,500.00)	123.1
210402	Тээвэр, шатахуун	48,266,700.00	51,575,050.00	(3,308,350.00)	106.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,843,300.00	11,542,470.00	5,300,830.00	68.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,249,300.00	14,374,680.00	874,620.00	94.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37,231,600.00	39,088,340.50	(1,856,740.50)	105.0

2105	Нормативт зардал	292,955,200.00	275,833,016.00	17,122,184.00	94.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	366,700.00	30,500.00	336,200.00	8.3
210502	Хоол, хүнс	275,788,500.00	259,853,541.00	15,934,959.00	94.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,800,000.00	15,948,975.00	851,025.00	94.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,126,200.00	39,060,946.00	65,254.00	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,494,900.00	15,063,858.00	(568,958.00)	103.9
210604	Урсгал засвар	24,631,300.00	23,997,088.00	634,212.00	97.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,200,000.00	4,200,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	4,200,000.00	4,200,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,200,000.00	4,200,000.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,200,000.00	4,200,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,520,100.00	0.00	3,520,100.00	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,520,100.00	0.00	3,520,100.00	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,520,100.00	0.00	3,520,100.00	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,301,934,700.00	2,280,709,302.50	21,225,397.50	99.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,470,346,700.00	1,429,822,684.69	40,524,015.31	97.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,470,346,700.00	1,429,822,684.69	40,524,015.31	97.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	831,588,000.00	850,886,617.81	(19,298,617.81)	102.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	781,588,000.00	740,763,817.81	40,824,182.19	94.8
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000,000.00	110,122,800.00	(60,122,800.00)	220.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	

